



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/156

Мандалговь

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан
оготонотой тэмцэх ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын а, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/86 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Сайнцагаан, Луус, Сайхан-Овоо, Дэрэн, Говь-Угтаал, Гурвансайхан сумдын нийт 20,0 мянган га малын бэлчээрийн талбайд үлийн цагаан оготонотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2019 оны 4 сарын 22 өдрөөс эхлэн 30 хоногт багтаан явуулсугай.

Хоёр. Уг ажиллагаанд шаардагдах улсын төсвөөс хуваарилагдсан зардал дээр сум бүр санхүүгийн дэмжлэг нэмж үзүүлэх, орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах, голомт бүхий малчин өрхөөс тус бүр 1 малчныг ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготонотой тэмцэх ажиллагааг зохион байгуулахдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлэхийг сумдын Засаг дарга нарт чиглэл болгосугай.

Дөрөв. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан, тэмцэх талбай болон санхүүжилтийг хуваарилах, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэнд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргал болон холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

488190428

Тав. Үлийн цагаан оготонотой тэмцэх ажлыг төсөвт зардалд багтаан технологийн хугацаанд чанартай, үр дүнтэй хийж тайлагнахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Зургаа. Ажлын явцад байнгын хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-д үүрэг болгосугай.

Долоо. Хүнс Хөдөө аж ахуйн сайд, аймгийн Засаг дарга нарын хооронд 2019 онд хамтран ажиллах үр дүнгийн гэрээний бэлчээрийн ургамал хамгааллын талаар тусгагдсан ажлыг үр дүнтэй зохион байгуулж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

Найм. 2019 онд бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх ажиллагаанд хамрагдах сумдын нэр, тэмцэх бэлчээрийн талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн
156 дугаар захирамжийн хавсралт

БЭЛЧЭЭРИЙН ҮЛИЙН ЦАГААН ОГОТОНТОЙ МИКРОБИОЛОГИЙН АРГААР
ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ ХИЙГДЭХ СУМД, ТЭМЦЭХ ТАЛБАЙ, БЭЛДМЭЛИЙН
ХУВААРЬ

| Д/д | Сумдын нэр | Үлийн цагаан оготно тархсан талбай мян/га | Тэмцэх талбайн хэмжээ мян/га | Бэлдмэлийн хэмжээ /тн/ | Шуудай |
|-----|--------------|---|---------------------------------------|---------------------------|-------------|
| 1 | Эрдэнэдалай | 397,5 | 2,5 | 5 | 142 |
| 2 | Адаацаг | 213,2 | 2,3 | 4,6 | 130 |
| 3 | Дэлгэрцогт | 26,0 | 1,0 | 2 | 57 |
| 4 | Дэрэн | 186,0 | 2,8 | 5,7 | 165 |
| 5 | Цагаандэлгэр | 100,0 | 2,8 | 5,7 | 165 |
| 6 | Луус | 18,6 | 1,2 | 2,4 | 67 |
| 7 | Сайхан-Овоо | 3,0 | 2,0 | 4 | 114 |
| 8 | Сайнцагаан | 137,7 | 2,4 | 4,5 | 128 |
| 9 | Говь-Угтаал | 253,7 | 2,0 | 4 | 114 |
| 10 | Гурвансайхан | 81,6 | 1,0 | 2,1 | 60 |
| | Нийт | 1466,1 | 20,0 | 40 | 1142 |